



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 707

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасч,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дахь заалт, 2008 оны 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 17 нэрийн нийт 26,128,670.00 /хорин зургаан сая нэг зуун хорин найман мянга зургаан зуун далан/ төгрөгийн балансын үнэ, 17,579,544.26 /арван долоон сая таван зуун далан есөн мянга таван зуун дөчин дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг данснаас хасч хавсралтад заасны дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Л.Эрдэнэчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201555

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
707 дугаар тогтоолын хавсралт

**Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын данснаас хасч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт
бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Хьюндай Айро маркийн автобус, улсын дугаар УНД 43-36	2013/12/09	ш	1	17,850,210.00	17,850,210.00	17,279,914.26	570,295.74
2	Суурин компьютер	2018/11/16	ш	1	1,372,250.00	1,372,250.00	256,265.00	1,115,985.00
3	Компьютерын дэлгэц	2012/10/29	ш	1	232,210.00	232,210.00	43,365.00	188,845.00
4	РН метр	2012/10/29	ш	6	25,000.00	150,000.00		150,000.00
5	Лазер метр	2012/10/29	ш	4	37,500.00	150,000.00		150,000.00
6	Дижитал штангенциркуль	2012/10/29	ш	2	7,500.00	15,000.00		15,000.00
7	Метал, гагнуурын гэмтэл согог илрүүлэгч	2013/12/09	ш	1	1,000,000.00	1,000,000.00		1,000,000.00
8	Модны диаметр хэмжигч	2013/12/09	ш	1	950,000.00	950,000.00		950,000.00
9	Хий шалгагч	2013/12/09	ш	1	450,000.00	450,000.00		450,000.00
10	Бетоны бат бөх тодорхойлогч алх	2013/12/09	ш	2	400,000.00	800,000.00		800,000.00
11	Металлын хатуулаг /нягт/ хэмжигч	2013/12/09	ш	1	800,000.00	800,000.00		800,000.00
12	Барилгын материалын бат бэх чанар хэмжигч	2013/12/09	ш	1	800,000.00	800,000.00		800,000.00
13	Теоделит /Электрон тахеометр/	2013/12/09	ш	1	900,000.00	900,000.00		900,000.00
14	РН метр /зөөврийн/	2013/12/09	ш	1	34,000.00	34,000.00		34,000.00
15	РН метр /зөөврийн ORP/	2013/12/09	ш	2	250,000.00	500,000.00		500,000.00
16	Металлын зузаан хэмжигч	2013/12/09	ш	1	80,000.00	80,000.00		80,000.00
17	Газардуулгын эсэргүүцэл хэмжигч	2013/12/09	ш	1	45,000.00	45,000.00		45,000.00
						26,128,670.00	17,579,544.26	8,549,125.74
	Нийт дүн			28		/Хорин зургаан сая нэг зуун хорин найман мянга зургаан зуун далан/	/арван долоон сая таван далан есөн мянга таван зуун дөчин дөрвөн төгрөг хорин зургаан мөнгө/	/найман сая таван зуун дөчин есөн мянга нэг зуун хорин төгрөг далан дөрвөн мөнгө/